




Хэрэглэгчийн хүлээлтийн индексийн судалгаа (2010 оны нэгдүгээр улирал)

Товч агуулга |

Хэрэглэгчийн хүлээлтийн индекс(ХХИ)

Хэрэглэгчийн хүлээлтийн индекс нь олон улсад өргөн ашиглагддаг маш өндөр ач холбогдол бүхий эдийн засгийн индикатор юм. ХХИ нь тэргүүлэгч индикаторуудын нэг бөгөөд хэрэглэгчдийн ирээдүйн эдийн засгийн хүлээлтийг харуулдаг байна. Эдийн засаг дахь хэрэглэгчдийн үйл хөдлөл, ирээдүйн байдлын талаархи хүлээлт нь нийт эдийн засгийн хандлагад чухал нөлөө үзүүлж байна. Тиймээс дэлхийн олон улс орон хэрэглэгчдийнхээ үйл хөдлөл, хүлээлт дээр тулгуурласан индексийг тооцож, шийдвэр гаргах чухал үзүүлэлт болгон ашигласаар байна. Энэ нь зөвхөн улс орны бодлого боловсруулахаас гадна бизнес эрхлэгчдэд эдийн засгийн ирээдүйн таамаглал гаргаж ажил хэргээ удирдахад чухал ач холбогдолтой. Өнөө үед хэрэглэгчдийн гаргаж буй шийдвэр нь эдийн засгийг бүхэлдээ тодорхойлох болжээ. Ийм учраас Америкийн Conference Board, Германы ZEW зэрэг байгууллагуудаас гаргадаг хэрэглэгчдийн хүлээлт нь эдийн засгийн ирээдүйн чиг хандлагыг гайхалтай сайн харуулж чаддаг байна.



Дээрх графикт Америкийн хэрэглэгчийн хүлээлтийн индекс ба Америкийн ажил эрхлэлтийн түвшний хамаарлыг харуулжээ. Энэхүү Америкийн өнцөг булан бүрт амьдарч буй 500 хүнээс авдаг санал асуулга нь ажилгүйдлийн түвшний өөрчлөлтийг хэрхэн оновчтой таамаглаж байсныг графикаас тодорхой харж болно.

Манай улсын хувьд анх 2009 оноос эхлэн Санхүүгийн зах зээлийн холбоо болон Нээлттэй Нийгэм Форум уг индексийг Улаанбаатар хотын хэмжээнд тус тусдаа тооцож эхэлсэн юм. Энэхүү индикатор нь хувь хүн, айл өрх, албан байгууллага, улс орны хэмжээний богино, дунд, урт хугацааны шийдвэр гаргалтад нөлөөлөхүйц эдийн засгийн чухал үзүүлэлт болон ашиглагддаг онцгой ач холбогдолтой билээ.

2010 оны нэгдүгээр улирлаас эхлэн Санхүүгийн зах зээлийн холбоо, Нээлттэй Нийгэм Форум хамтран энэхүү индексийг тооцоолж эхэллээ.

Монголын хэрэглэгчийн хүлээлтийн индексийг тооцох аргачлал

XXI-ийг Монгол улсын эдийн засгийн бүтцэд тохируулан улирал тутамд нэг удаа, нийт 1000 хүнээс санал асуулга авах замаар гаргаж байна. Эдгээр санал асуулгад хариулагчид нь Монгол улсын нийгэм, эдийн засгийн бүтцийг төлөөлөхүйц байдлаар статистик түүврийн аргаар сонгогдож байгаа юм. Хэрэглэгчийн хүлээлтийн индексийн санал асуулга нь өөртөө Хэрэглэгчийн хүлээлтийн **индекс** болон **индикаторыг** агуулдаг. Индекс нь хэрэглэгчдийн хүлээлт өмнөх үетэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулдаг бол индикатор нь хэрэглэгчдийн эдийн засгийн талаарх ерөнхий хүлээлт эерэг эсвэл сөрөг байгаа эсэх, мөн хэр эерэг, хэр сөрөг байгаа талаар харуулдаг ач холбогдолтой. Санал асуулга нь индекс болон индикаторыг тооцоолоход ашиглагдах үндсэн 5 асуулттай бөгөөд индексийн бодитой байдлыг хангах зорилго бүхий 20 нэмэлт асуултыг давхар агуулдаг. Асуултууд нь ерөнхийдөө одоогийн нөхцөл байдал ба ирээдүйн хүлээлт гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ. XXI нь а.Хэрэглэгчдийн хэрэглээний хандлагад гарч байгаа өөрчлөлт, хүлээлт, б.Инфляци, в.Ажилгүйдэл, г.Банкны сеткорын талаарх хэрэглэгчдийн байр суурь, д.Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн талаарх нийгмийн байр суурь гэсэн үндсэн 5 чиглэлээр хэрэглэгчид ирээдүйд ямар хүлээлттэй байгааг тодруулах зорилготой юм.


Хэрэглэгчийн хүлээлтийн индексийн судалгааг санамсаргүй түүврийн аргаар доорх эдийн засгийн 13 салбарын нийт 1000 хүнээс асуулга авч тооцдог.

- ХАА
- Уул уурхай
- Боловсруулах үйлдвэр
- Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж
- Барилга
- Бөөний, жижиглэнгийн худалдаа
- Зочид буудал, зоогийн газар, ресторан
- Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо
- Санхүү
- Үл хөдлөх хөрөнгө
- Төр, батлан хамгаалах
- Боловсрол
- Эрүүл мэнд

5 дахь удаагийн энэхүү судалгаанд 20 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаж дээр дурдсан 13 салбарт ажиллагсдын төлөөллөөс биечлэн очиж асуулга авсан болно. Судалгааны асуулга нь нийт 25 асуулттай бөгөөд эхний хэсэг нь оролцогчдоос ерөнхий мэдээлэл авах, хоёрдох хэсэг буюу 1-10 дугаар асуулт хэрэглэгчдийн ирээдүйн хандлагыг тодорхойлох, гуравдахь хэсэг буюу 11-17 дугаар асуулт хэрэглэгчдийн банк санхүүгийн байгууллагад итгэх итгэлцүүрийг тодорхойлоход оршдог. Харин сүүлийн дөрөвдүгээр хэсэг нь 2-4 нээлттэй асуултаас бүрдэх ба төрөөс явуулж буй бодлого, гаргасан шийдвэрүүд, тэдгээрийн үр дүнгийн талаар иргэд ямар хүлээлттэй байгааг тодруулах зорилготой болно.

2009 онд Хэрэглэгчийн хүлээлтийн индексийг тооцохдоо 2 дугаар улирлыг индексийн суурь болгон авсан бөгөөд 3 болон 4 дүгээр улиралд индексийг тооцохдоо 2 дугаар улирлын дүнтэй харьцуулан тооцсон болно. Өнгөрсөн хугацаанд индексийг тооцоход манай улсын хувьд төр, засгийн газраас гаргаж байгаа болон бусад улс төрийн хүчнүүдээс нийгэмд түгээгдэж байгаа

мэдээллүүд нь хэрэглэгчдийн ирээдүйн хандлагад ихээхэн нөлөө үзүүлдэг болох нь ажиглагдсан. Тухайлбал сая таван зуун мянган төгрөгийг өнөө маргаашгүй өгөх боллоо, Монгол Улс хямралаас гарлаа хэмээн засгийн газраас хүчтэй зарлаж байсан нь өнгөрсөн оны 3 дугаар улиралд индексийг огцом буюу 20 нэгжээр өсөхөд хүргэсэн байна. Гэтэл мөн оны 4 дүгээр улирлын дүн нь 111,83 гарч урд улирлын дүнгээсээ даруй 10 нэгжээр бага байгаа нь хэрэглэгчдийн хүлээлтэд эдгээр мэдээллүүд нь ихээхэн нөлөөлдөг болохыг харуулж байна.





Түүнчлэн 2009 онд явуулсан судалгааны дүнгээс харахад тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хэрэглэгчдийн санаа бодлыг харуулдаг ерөнхий индикатор 48,2 байсан нь 2009 онд хэрэглэгчдийн дунд эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын талаар бага зэрэг сөрөг хандлага давамгайлж байсныг харуулж байна.

ХХИ 2010 оны 1-р улирал | Хэрэглэгчдийн хүлээлт сайжирч байна...

2010 оны эхний улирлын ерөнхий индикатор 49,05 гарч 2009 онтой харьцуулахад хэрэглэгчдийн эдийн засгийн төлөв байдлын талаарх сөрөг хандлага буурч байгаа нь ажиглагдлаа. Индикатор нь 0-100 хүртэл интервалтай байдаг бөгөөд 50-аас дээшээ гарвал хэрэглэгчийн макро эдийн засгийн ерөнхий хүлээлт эерэг, харин 50-аас доошоо гарвал макро эдийн засгийн ерөнхий хүлээлт сөрөг байгааг тус тус харуулна. Хэдийгээр хүлээлт сөрөг хэвээр байгаа боловч индексээс харахад ирээдүйд итгэх итгэл нэмэгдэж эхэлснийг харж болно. Хэрэглэгчийн хүлээлтийн индексийг 2009 оныг суурь он болгон тооцоход 104,51 буюу 4.51 хувийн өсөлттэй гарсан нь хэрэглэгчдийн хувьд ойрын үед эдийн засагт өсөлт гарна гэсэн хүлээлт байгааг харуулж байна. Энэхүү хүлээлт нь иргэдийн худалдан авалтыг нэмэгдүүлэх магадлалтай гэдгийг анхаарах нь зүйтэй. Хэрэглэгчдийн хүлээлт ийнхүү сайжрах болсон нь уул уурхай түшиглэсэн хөгжил бодитой зүйл болж эхэллээ гэсэн ард түмний хүлээлт мөн засгийн газраас ард иргэдэд тарааж буй бэлэн мөнгөтэй зарим талаар холбоотой гэж бид үзэж байна.

2010 оны 1-р улиралд инфляцийн түвшин мэдэгдэхүйц өсч гарсан нь хэрэглэгчдийн хүлээлт 2009 оны 3-р улирлаас эхлэн сайжирч байсантай уялдаж байгаа бөгөөд энэ удаагийн судалгаанаас үзэхэд хэрэглээ цаашид үргэлжлэн нэмэгдснээр инфляци улам бүр өсөх эрсдэлтэй байгааг харуулж байна.




Дэлхийн тэргүүлэгч гүрэн болох АНУ-ын 2010 оны 1-р улирлын Хэрэглэгчийн хүлээлтийн индексийг үзэхэд тухайн улирлын индекс нь 73,45 гарч байгаа нь Америкчуудын эдийн засгаасаа хүлээх хүлээлт нэлээд сул байгааг харуулж байна. Энэ нь АНУ-аас эхлэлтэй гэж үзэж байгаа дэлхийн эдийн засгийн хямрал намжаагүй, иргэдийн амьдралд одоог хүртэл сөрөг нөлөө үзүүлсээр байгаагаар холбоотой.

2010 оны эхний улирлын Монголын хэрэглэгчийн хүлээлтийн ерөнхий индикатороос гадна өнөөгийн нөхцөл байдлын болон ирээдүйн нөхцөл байдлын индикаторыг тооцож үзэхэд

- Өнөөгийн нөхцөл байдлын индикатор – 39,25
- Ирээдүйн нөхцөл байдлын индикатор – 58,85 тус тус гарлаа.

Өнөөгийн нөхцөл байдлын индикатор нь хэрэглэгчид өөрийн болоод улс орны эдийн засгийн өнөөгийн төлвийн талаар ямар бодолтой байгааг харуулдаг бол ирээдүйн нөхцөл байдлын индикатор нь хэрэглэгчид эдийн засгийн ирээдүйн хандлагын талаар ямар хүлээлттэй байгааг харуулдаг. Уг индикаторууд 50 - иас дээш байвал одоогийн болоод ирээдүйн эдийн засгийн байдал сайн (эерэг) байгааг харуулах бол 50 – иас доош байвал дээрхийн эсрэг утгыг агуулдаг.



Судалгааны дүнд өнөөгийн нөхцөл байдлын индикатор өмнөх улирлаас өндөр гарсан нь хэрэглэгчид эдийн засгийн өнөөгийн байдлыг өнгөрсөн улирлынхаас илүү сайжирсан гэж үзэж байгаа хэрэг боловч 50-иас доогуур үзүүлэлттэй байгаа нь хэрэглэгчдийн дунд ерөнхийдөө сөрөг хандлага давамгайлж байгааг илтгэж байна. Харин ирээдүйн нөхцөл байдлын индикатор 2009 оны 4 дүгээр улиралтай харьцуулахад ялимгүй буурсан хэдий ч 58,85 хувьтай байгаа нь хэрэглэгчид эдийн засгийн ирээдүйн төлөв байдлын талаар эерэг хүлээлттэй байгааг харуулж байна.




Судалгаанд оролцогчдыг насны бүтцээр авч үзвэл нийт оролцогчдын 48 хувийг 18-29 насныхан, 42 хувийг 30-49 насныхан, 9 хувийг 50-59 насныхан, үлдсэн 1 хувийг 60-аас дээш насныхан тус тус эзэлж байна. Эндээс дүгнэж үзэхэд уг судалгаа нь хүн амын эдийн засгийн идэвхтэй хэсгийг хамарч чадсаныг илтгэж байна.




Судалгаанд оролцогчдыг орлогын бүлгээр авч үзвэл нийт оролцогчдын 10 орчим хувийг 100.000,00 - 300.000,00 төгрөгийн орлоготой иргэд харин 45 хувийг 300.000,00 – 500.000,00 төгрөгийн орлоготой иргэд эзэлж байна.

Та Монголын банкуудыг хэр найдвартай гэж бодож байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчид дараах хариултыг өгсөн байна.



Хариултын дүнгээс харахад судалгаанд оролцсон нийт иргэдийн 33 хувь нь банкууд найдваргүй гэсэн хариултыг өгчээ. Энэ нь банкны салбарын үйлчилгээ муу, хэд хэдэн банк ар араасаа дараалан хүнд байдалд орж зарим нэг нь дампуурсан зэрэгтэй холбоотой гэж үзэж байна.

Танай гэр бүлийн өдөр тутам хэрэглэдэг бараа бүтээгдэхүүний үнэ сүүлийн нэг жилийн хугацаанд хэрхэн өөрчлөгдсөн бэ? гэсэн асуултад доорх хариултыг өгсөн байна.



Судалгааны үр дүнгээс үзэхэд судалгаанд оролцогсдын 60 гаруй хувь нь өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ сүүлийн нэг жилийн хугацаанд өссөн гэж хариулсан байна. Мөн үнэ цаашид өснө гэж нийт судалгаанд оролцогчдийн 60 гаруй хувь нь хариулжээ. Эндээс дүгнэж үзэхэд хэрэглэгчдийн хувьд үнийн дарамт тэдгээрийн хэрэглээнд хүчтэй нөлөө үзүүлж байна гэж хэлж болохоор байна.

Эдийн засгийн тогтвортой байдлын талаарх хамгийн чухал үзүүлэлтүүдийн нэг болох ажил эрхлэлтийн талаар асуусан асуултанд судалгаанд оролцогчдын ихэнх буюу 70 гаруй хувь нь ажлын байраа ирэх жилийн хугацаанд солих бодолгүй байгаа, мөн 70 гаруй хувь нь энэ ажлын байр нь цаашид ч тогтвортой байна гэж хариулснаас үзэхэд манай улсын хувьд огцом ажилгүйдэл нэмэгдэх болон бүтцийн ажилгүйдлийн түвшин цаашид ч өөрчлөлт багатай байх болно гэсэн дүгнэлтийг хийхэд хүргэж байна.

Бид энэ удаагийн судалгаандаа цаг үеийн буюу төрөөс явуулж буй бодлого, гаргасан шийдвэрүүд, тэдгээрийн үр дүнгийн талаар “Таны бодлоор төрөөс иргэдэд бэлэн мөнгө олгосноор ямар үр дагаварт хүрэх бол?”, “Таны бодлоор бид өнөөдөр уул уурхайн ордуудаа бүгдийг нь яаралтай ашиглах шаардлага байна уу?” гэсэн 2 нээлттэй асуулт оруулж өгсөн. Эхний асуултад судалгаанд оролцогчдын дийлэнх олонхи нь мөнгө тараах нь буруу, инфляцийг хөөрөгдөж, иргэдэд бэлэнчлэх сэтгэлгээ суулгаж байна, үүний оронд үйлдвэр бариад хэсэг хүнийг ажлын байраар хангавал эдийн засагт үзүүлэх үр өгөөж нь хавьгүй илүү гэж хариулжээ. Харин дараагийн асуултад хүмүүсийн ихэнх хувь нь ордуудаа ашиглах шаардлагатай гэж үзэж байгаа хэдий ч зөв зохистой ашиглан ажлын байр бий болгож эдийн засгийг дээшлүүлж үр өгөөжийг нь ард түмэндээ хүртээх нь хамгийн чухал гэж хариулжээ.

